## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 9

Хуралдаан 2013 оны гуравдугаар сарын 28-ны өдрийн 14 цаг 10 минутад эхэлж,16 цаг 00 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 50 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | 2013 оны 3 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга<br>- Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны дарга<br>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга | Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун, Даваахүүгийн Наранпүрэв нарыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх<br>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан Ёндон-Ойдовын Гэрэлчулууныг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүлд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд |

| | | |
|---|---|---|
| | | томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Болдын Бадрал, Лувсандагвын Пүрэвбаатар, Мөнхжаргалын Энхболд нарыг Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.<br>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан Болдын Бадралыг Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүлд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Бөхчулууны Энхболдыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.<br>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан Бөхчулууны Энхболдыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, |

| | | |
|---|---|---|
| | | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баттулгад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 2 | Батлан хамгаалах яамны зарим газар (3)-ын даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай<br>- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга<br>- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга<br>- Гадаад хамтын ажиллагааны газрын дарга | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Оргодолын Нямчулууныг, тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд Даяндоржийн Жаргалсайханыг, Гадаад хамтын ажиллагааны газрын даргын албан тушаалд Дорждэрэмийн Ганхуягийг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Болдбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 3 | Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн |

| | | |
|---|---|---|
| | | ерөнхий газрын дэд даргын албан тушаалд Гомбодоржийн Цэцгээг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 4 | Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд уг албан тушаалын нөөцөөс Д.Мөнх-Эрдэнийг томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд удирдах ажилтны нөөцөөс Даваажавын Мөнх-Эрдэнийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Говьсүмбэр аймгийн Засаг дарга Л.Отгонжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 5 | Говьсүмбэр аймгийн ИТХТ-ийн даргаар ажиллаж байсан Г.Сайнбаярыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :<br>Говьсүмбэр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байсан Г.Сайнбаярыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |

| | | |
|---|---|---|
| 6 | Сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний төвийг өөрчлөн байгуулах тухай | Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний төвийн үйл ажиллагааны дүрмийг сайтар нягтлан боловсруулж, бусад асуудлыг тодруулан баталгаажуулахыг даалган, дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлуулав. |
| 7 | Бусад асуудал:<br>- Төрийн албаны зөвлөлийн 2012 оны үйл ажиллагааны тайланг сонсох | Төрийн албаны зөвлөлийн 2012 оны үйл ажиллагааны тайланд Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн саналыг нэмж тусгахаар тогтлоо. |

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**